



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 24 өдөр

Дугаар А/614

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а", Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний эрх шилжүүлэх тушаалын IX.2.1.16 дахь заалтын "Хүүхдийн тоглоомын паркийн шинэчлэл /Ховд, Жаргалант сум/" ажлын гүйцэтгэгч "Ховд мөнх түшиг" ХХК-ний хийж гүйцэтгэсэн ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Ганданповрон – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Б.Даваадорж – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Н.Ганбат – "Мянган угалзат" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга

Б.Түмэндэмбэрэл – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

М.Өлзийхүү – "Ховд мөнх түшиг" ХХК-ний захирал

Э.Цолмон – Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Д.Бямбасүрэн - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

D/Zax-A/617-Da

02 03076

2. “Хүүхдийн тоглоомын паркийн шинэчлэл /Ховд, Жаргалант сум/” ажлыг зураг, төсөв, ажлын даалгаврын дагуу шалгаж хянан баталгаажуулж шийдвэр гаргаж хүлээн авахыг ажлын хэсгийн ахлагч /Ц.Ганданповрон /-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ